



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 9/105

Бор-Өндөр сум

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх  
дархлаажуулалт, лабораторийн шинжилгээний  
ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 6.6 дахь хэсэг, 9 дүгээр зүйл, 28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 225 дугаар тогтоол, Хэнтий аймгийн Засаг даргын 2025 оны А/212 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт, лабораторийн шинжилгээг сумын хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч

Б.Болормаа

Нарийн бичгийн дарга

Р.Цэндсүрэн

Гишүүд

И.Энхтуяа

У.Пүрэвсүрэн

Д.Мөнгөнтуяа

Ч.Саруулмөнх

Б.Мөнх-Оргил

Н.Отгонбилэг

Ц.Бат-Эрдэнэ

Ц.Төртүвшин

Мал эмнэлгийн хяналтын Улсын байцаагч

Тархвар зүйч

Бор-Өндөр 1 дүгээр багийн Засаг дарга

Холбоо 2 дугаар багийн Засаг дарга

Бумбат 3 дугаар багийн Засаг дарга

Уурхайчин 4 дүгээр багийн Засаг дарга

Хүйх 5 дугаар багийн Засаг дарга

Өлгий 6 дугаар багийн Засаг дарга

"Ноён Зүлэгт" ХХК МЭҮН-ийн захирал

"ЭнТэЧи" ХХК МЭҮН-ийн захирал

2. Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт, лабораторийн шинжилгээний арга хэмжээг 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс

D:/bichig hereg/Захирамж.docx


эхлэн 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулахыг Мал эмнэлгийн тасагт үүрэг болгосугай.

3. Мал эмнэлгийн төлөвлөгөөт арга хэмжээг орон нутагтаа графикт хугацаанд нь шуурхай хийж гүйцэтгэхийг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн Малын эмч (Ц.Бат-Эрдэнэ, Ц.Төртүвшин) нарт, Урьдчилан сэргийлэх тарилга, лабораторийн шинжилгээг хийхэд мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, зохион байгуулах, ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавьж дүнг нэгтгэж танилцуулахыг Мал эмнэлгийн тасагт даалгасугай.

4. Мал эмнэлгийн арга хэмжээнд мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлсхийсэн малчин, мал бүхий иргэд, заавар журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцөлийг бүрдүүлсэн албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Мал эмнэлгийн хяналтын Улсын байцаагч (Б.Болормаа)-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (З. Ууганжаргал)-д, гүйцэтгэлийг 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор танилцуулж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч (Р.Цэндсүрэн)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ